

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Судруудаас удирдамж хүлээн авах нь

Далын ахлагч, Азийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн 1-р зөвлөх Ларри Я.Вилсон

Бид Бурхантай залбирлаар дамжуулан ярьдаг харин Тэрээр бидэнд судруудаар дамжуулан хариу өгдөг гэж Сүмд олонтоо ярьдаг. Бид судруудыг унших үедээ Сүнсээрээ дамжуулан ярьж байгаа Түүний үгсийг сонсох онцгой эрхтэй болдог. Сургаал ба Гэрээ 18:34-36-д “Эдгээр үгс нь хүмүүсийнх буюу хүнийх биш, харин минийх бөлгөө. . . Учир нь тэдгээрийг та нарт ярьсан нь миний дуу хоолой болой; учир нь миний Сүнсээр та нарт тэдгээр нь өгөгдсөн авай, . . . Иймийн тул, миний дуу хоолойг сонссоноо, мөн миний үгийг мэднэ гэдгээ та нар гэрчилж чадна” хэмээн заасан. Бид залбирч, Сүнс биднийг удирдаж буйг мэдрэснээр үнэхээр Их Эзэний дуу хоолойг сонссоноо гэрчилж чадна.

Миний эхнэр Сүмийн хөрвөгч юм. Тэрээр шашны ямар нэгэн нөлөөгүй гэр бүлд өссөн билээ. Тэр 11 настай байхдаа Сүмд хэдэн жилийн өмнө хөрвөгдсөн эмээгээсээ Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар сонсчээ. Миний эхнэр эмээгээ орой бүр унтахынхаа өмнө орон дээрээ суугаад судар уншихыг хардаг байсан сайхан дурсамжтай билээ. Түүний эмээ судраа нээж, уншиж эхлэх үед

Их Эзэний дуу хоолой ирдэг гэдгийг мэддэг байсан бөгөөд ач охиндоо гайхамшигтай жишээ үзүүлжээ.

Жил гаруйн өмнө би Монголд нэгэн гишүүний гэрт зочлох боломжтой болсон юм. Гэрт нь орох үед судрууд бас Лиахона сэтгүүл дэлгээстэй байсан бөгөөд намайг гэртээ урьсан эгчээс би юу уншиж байгааг нь асуухад тэрээр нээлттэй судраа аван, Алма 27:27-ийн дараах үгсийг уншсан юм: “Мөн тэд Нифайн хүмүүсийн дунд байж, мөн түүнчлэн Бурханы сүмд байсан хүмүүсийн дунд тоологдов. Мөн тэд түүнчлэн Бурханд хандсан, мөн түүнчлэн хүмүүст хандсан өөрсдийн хичээл зүтгэлээр онцгойлогдсон байв; учир нь тэд бүх зүйлд төгс шударга мөн зөв шулуун байв; мөн тэд Христэд итгэх итгэлдээ бүр эцсээ хүртэл гуйвшгүй байв.” Тэр эгч Мормоны Номонд эдгээр хүмүүсийг хэрхэн тодорхойлсныг уншаад урам зориг авснаа надад хэлсэн юм.

Тэр эгч Нифайн энэ шүлэгт дүрсэлсэн хүмүүстэй их адилхан юм байна гэж би дотроо бодож билээ. Бурханыг дагах түүний хүсэл судруудыг хичээнгүйлэн уншиж байгаагаар нь батлагдсан юм. Би түүнээс Лиахонагоос юу уншиж байсныг нь асуухад



Далын ахлагч
Ларри Я.Вилсон

хамгийн сүүлийн Ерөнхий чуулган дээр хэлсэн ахлагч Рассэлл М.Нэлсоны үгийг онцлоод надад дүгнэн хэлэхэд нь “Энд Бурханы дуу хоолойг судрууд болон амьд бошиглогчдоор дамжуулан сонсож байгаа нэгэн эгч байна. Бурхан түүнийг олж мэдсэн захиасуудаар нь дамжуулан Христтэй илүү адилхан болоход удирдаж байна” гэж би бодож билээ.

Олон жилийн өмнө манай нэг найз Нэгдсэн Улсын баруун хэсэг дэх Грэнд Канён (Grand Canyon буюу гүн хавцлаар хүрээлэгдсэн газар)-аар сүмийн хэсэг

хөвгүүдтэй хамт явган аялал хийсэн юм. Тэд хавцал руу улам бүр доошлон уруудаж байсан ба найз маань маш хүнд ачаатай явж байжээ. Ачааны хүндээс болоод түүний өвдөг гэмтэж, тэр явж чадахаа болив. Тэгээд тэд түүнийг хавцлаас гаргах аврах бүлгийг дуудав. Аврах бүлгийнхэн түүнийг хавцлаас гаргаж байх үед тэрээр Мормоны Номоос 2 Нифай 4:20-ийг санамсаргүй нээгээд “Миний Бурхан миний дэмжлэг байсан; тэрээр аглаг буйда хь зовлонгуудын минь дундуур намайг удирдсан; мөн тэрээр гүн далай дээр намайг хамгаалсан билээ” гэж уншжээ. Тэрээр дэргэд нь байгаа Аврагчийнхаа аврах хүчийг мэдэрснээр уг судар түүний зүрх сэтгэлийг дүүргэсэн юм.

Нифай зовлон дундуур туулсан өөрийнхөө туршлагыг эдгээр үгээр тодорхойлж бичсэн хэдий ч найз маань зовлонт үед өөрт нь ижил зүйлийг хэлж буй Их Эзэний дуу хоолойг сонссон юм. Судруудын үгсээр дамжуулан ярих Их Эзэний үгийг сонсох түлхүүрийн нэг нь өөрсөдтэйгөө адилтгах ур чадварт суралцах явдал юм. Нифай “Мөн би. . . бичигдсэн байсан тэр олон зүйлийг [гэр бүлийнхэндээ] уншиж өгсөн болой; гэвч би тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгаж болно хэмээн би тэдэнд бошиглогч Исаиагийн бичиглэснийг уншиж өгөв; учир нь энэ нь бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би *бүх судрыг*

өөрсөдтэйгөө адилтгасан билээ” (1 Нифай 19:23) гэж тайлбарлажээ.

Хүмүүс Сүмийн шинэ гишүүн болох үедээ эсвэл хүүхдүүд Сүмд өсч торних үедээ судруудыг хэрхэн өөрсөдтэйгөө адилтгахыг төдийлөн сайн мэддэггүй. Үүнийг хийж сурах хамгийн шилдэг аргуудын нэг нь үүнийг хэрхэн хийхийг мэддэг Сүмийн туршлагатай гишүүнтэй хамт унших явдал юм. Олон хүн судрыг хэрхэн үр дүнтэй уншихаа сайн мэддэггүй. Тэд уншиж байх үедээ Их Эзэний дуу хоолойг сонсож сурахыг хүсч байвал тэднийг удирдаж чадах хэн нэгний тусламж тэдэнд хэрэгтэй.

Үйлсийн 8-р бүлэгт Филип судруудыг уншиж, ойлгохдоо бэрхшээлтэй байсан нэгэн хүнтэй тааралдсан тухай түүх байдаг. Филип нь Арванхоёр төлөөлөгчид туслахаар сонгогдсон долоон эрийн нэг нь байсан юм (Үйлс 6:2-6). Тэр үед Филип “Тайган хүн” гэж нэрлэгдсэн нэг хүнтэй таардаг. Филип түүний уншиж байсан судар дээр Исаиа бүлэг нээлттэй байгааг хараад юу уншиж байгаагаа ойлгож байгаа эсэхийг түүнээс асуужээ. Тэр “Хэн нэгэн зааж өгөхгүй бол би хэрхэн ойлгох билээ?” (Үйлс 8:31) хэмээн хариулсан байдаг.

Ихэнх шинэ гишүүд болон өсвөр үеийнхэн үүнтэй адил асуудалтай тулгардаг. Хэн нэгэн зааж өгөхгүй бол тэд хэрхэн судруудыг өөрсөдтэйгөө адилтгаж, тэдэнд хандан ярьж буй Их Эзэний

дуу хоолойг сонсож сурах вэ? Тэд судрыг найзтайгаа эсвэл ямар нэгэн багштай хамт унших хэрэгтэй. Гишүүн бид бүгд Филиптэй адил тусламж хэрэгтэй хүмүүсийг эрж олон, тусалж байх хэрэгтэй бөгөөд тэдэнд судруудыг хэрхэн уншихыг заах хэрэгтэй. Ингэснээр тэд судруудаас хувийн сүнслэг хүч чадал болон удирдамжийг олж авах болно.

Хэдэн жилийн өмнө эхнэр, бид хоёр гэртээ засварын ажил хийлгэхээр нэг ажилчин хөлсөлж авсан юм. Түүнд ямар нэгэн шашны талаар итгэл үнэмшил байдаггүй байлаа. Бид түүнийг манайд ажиллаж байх үеэр нь сайн мэдээний тухай хэд хэдэн удаа ярилцсан юм. Хэдэн сарын дараа бид түүнд Мормоны Номыг өгч, бидэнтэй хамт сүмд явахад урьсан билээ. Удалгүй тэр номлогчидтой уулзаж, баптисм хүртсэн юм. Гэсэн хэдий ч, би түүнийг ням гаргийн анги дээр судраас уншихдаа зовниж байгааг нь анзаарсан бөгөөд энэ тухай түүнээс асуулаа. Тэр сайн уншиж чаддаггүй байсан бөгөөд 30 жилийн турш ном уншаагүй гэдгээ хэлсэн юм. Тэр Мормоны Номыг ганцаараа уншихгүй мөн хэзээ ч өөртэйгөө адилтгаж сурахгүй болохыг нь би ойлгосон юм. Иймээс би түүнд хамт уншихыг санал болгосон билээ.

Энэ нь Сүмийн гишүүн болсон энэ олон жилийн туршид тохиолдож байсан хамгийн сайхан туршлагуудын минь эхлэл болсон юм. Бид манай гэрт долоо хоногт хоёр

удаа уулзаж, цаг гаруй хамтдаа уншдаг байлаа. Сүмийн цуглааны дараа ням гаргийн үдээс хойш уулзах нь хамгийн тохиромжтой үе байсан бөгөөд тэрээр долоо хоногийн өөр нэгэн орой бас ирдэг байв. Бид хамт уншихдаа байн байн завсарлаж, түүний ойлгоогүй зүйлсийн талаар ярилцаж, уншиж байгаа зүйлсээ хэрхэн хувийн амьдралдаа хэрэгжүүлж болох талаар ярилцдаг байлаа. Судруудыг унших бүрд түүний сүнслэг суурь улам гүнзгийрч байгааг би мэдсэн юм. Өнөөдөр тэр Сүмийн хүчирхэг гишүүн болсон бөгөөд Мормоны Номын талаар гүн гүнзгий гэрчлэл, ойлголттой билээ. Тэрээр судрын үгийг өөртэйгөө хэрхэн адилтгахаа мэддэг бөгөөд судрын хуудсуудаас түүнд хандан ярьж буй Их Эзэний үгсийг сонсдог.

Энэ боломж нь судруудыг нээх бүрд бидэнд ирдэг юм. Бурханаас Өөрөөс нь ирэх удирдамжаас өөр ямар ч агуу эх сурвалж үгүй билээ. Хэрэв бид судруудыг уншиж, өөрсөдтэйгөө адилтгах аваас Тэрээр бидний өдөр тутмын хэрэгцээнд тусалж, хариултаудыг өгөх болно. Бид судруудаар дөнгөж аялж эхэлж байгаа хүмүүсийн судрын хамтрагч, найз нөхөр нь болох боломжийг эрж хайхын төлөө би залбирч байна. Тэгснээр бид бүгдээрээ хамтдаа “Таны үг бол миний хөл дэх дэнлүү, Миний зам дахь гэрэл юм” (Дуулал 119:105) хэмээн хэлэх болтугай. ■

Гарчиг: Ахлагч Ларри Я.Вилсон

Улаанбаатар дахь Сүмийн шинэ зохион байгуулалт

Орон нутгийн мэдээний редактор Н.Пүрэвсүрэн



2014 оны 3 сарын 1 ба 2-ны өдрүүдэд УБ Баруун Гадас ба Зүүн Дүүргийн хамтарсан чуулган чуулж, Улаанбаатар дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм зохион байгуулалтын том өөрчлөлт хийлээ. Уг чуулганд Азийн бүсийн ерөнхийлөгч Вилсон эхнэрийн хамт, Далын гишүүн ерөнхийлөгч Томпсон болон УБ Баруун гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, Монгол Улаанбаатар Номлолын ерөнхийлөгч Бэнсон эхнэртэйгээ мөн түүний зөвлөхүүд болон сүмийн удирдлагууд,

УБ Баруун гадасны ерөнхийлөгч Одгэрэл, 1-р зөвлөх Баатарчулуун, 2-р зөвлөх Цэрэнням

Азийн бүсийн ерөнхийлөгч Вилсон, Далын гишүүн, ерөнхийлөгч Томпсон, Монгол УБ Номлолын ерөнхийлөгч Бэнсон нар болон Зүүн Дүүргийн ерөнхийлөгч Адьяаболд, 1-р зөвлөх Энхбат, 2-р зөвлөх Бямбадорж





**Номлолын ерөнхийлөгч Бэнсон,
1-р зөвлөх Бат-Оргил, 2-р зөвлөх Ганхуяг**



Гадасны найрал дуучид дуулав



Ерөнхийлөгч Томпсон шинэ өөрчлөлтүүдийг танилцуулав

нийт сүмийн 900 гаруй гишүүн оролцлоо. Ерөнхийлөгч Вилсон ба түүний эхнэрийг үг хэлсний дараа ерөнхийлөгч Одгэрэл, ерөнхийлөгч Томпсон нар зохион байгуулалтын өөрчлөлтийг тодорхой танилцуулав. Улаанбаатар хотод УБ Баруун Гадас ба Зүүн Дүүрэг гэсэн зохион байгуулалт хэвээр байх боловч харин салбар, тойргуудын хил хязгаарт өөрчлөлт орж, шинээр Жаргалант ба Америкийн дэнж салбарууд бий болж, зарим тойрог ба салбарууд хил хязгаарын өөрчлөлтийн улмаас хуваагдав. Энэ бүхэн Бурхан амьд, Түүний сайн мэдээ үнэн гэдгийг мөн Түүний сүр хүчийг илтгэн харууллаа.

Христийн сайн мэдээний бүрэн байдал Монгол оронд анх түгэн дэлгэрснээс хойш 21 жил өнгөрч байна. Энэ хооронд Түүний сургаал өргөн цар хүрээтэй түгэн дэлгэрч, гишүүдийн тоо өсөн нэмэгдэж мөн цаашид гадаснуудын зохион байгуулалтад орох, Бурханы ариун өргөөг



Сүмийн гишүүд талархал, итгэлтэй хүлээн авав



Гадас ба Дүүргийн хамтарсан чуулган

нутагтаа босгох цаг мөчийг ойртуулах гайхалтай ажил бидний өмнө тулгарч байна. Энэ бол Түүний ажил бөгөөд үүнд саад болох зүйл гэж үгүй. Зөвхөн бид өөрсдөөсөө шалтгаалах бүхнээ хийх хэрэгтэй. ■

Сайн мэдээг шинэ технологи ашиглан түгээх нь

Манай Сүмийн арван тав дахь ерөнхийлөгч бидний хайрт бошиглогч Гордон Б.Хинкли орчин цагт цаг үеэ даган, шинэ технологийг зөв арга замаар мэдээлэл олж, түгээх, сайн мэдээг хуваалцах, ядарсан зүдэрсэн олонд дэмжлэг өгөх зэмсэг болгон ашиглах талаар зөвлөсөн байдаг бөгөөд сүмийн олон төлөөлөгч, удирдагчид ч мөн энэ талаар гишүүдэд хандан ярьсан байдаг. Манай Азийн бүсийн удирдлага Монголд үүнийг хөгжүүлэхэд олон арга замаар туслан дэмжиж байгаа бөгөөд саяхан албан ёсны вэб хуудастай болоход тусалснаар бид lds.mn гэсэн албан ёсны хуудастай боллоо. Үүнийг гишүүдэд мэдээлэн, сурталчлах зорилгоор 2014 оны 1 сарын 19-ны өдөр Баянзүрх байранд Хэвлэл мэдээллийн албаны захирал Цэрэнням галын дэргэдэх ярилцлагыг УБ Баруун гадас ба Монгол Улаанбаатар номлолын оролцоотой явууллаа. УБ Баруун гадасны ерөнхийлөгч Одгэрэл хэлсэн үгэндээ “1980-иад онд хэн нэгний захидал 40-80 хоногт хүрдэг байсан бол өнөөдөр далай тэнгис, тив дэлхийг

туулан, хэдхэн секундэнд шууд харилцах болжээ. Ийм цаг үед сайн мэдээ ч гэсэн ийм хурдтайгаар түгээгдэх ёстой” гээд С ба Г 15:6 дээрээс “хүмүүст наманчлалыг тунхаглах” тухай судар хуваалцлаа. Харин номлолын ерөнхийлөгч Бэнсон Монголд 1996-1999 онуудад бүрэн цагийн номлолд үйлчилж байснаа дурсан, “Тэр үед гар утас гэж байгаагүй тиймээс бид бүтэн долоо хоноогоор төлөвлөгөөгөө хийдэг байсан. Харин одоо номлогч бүр гар утсаараа шууд харьцах боломжтой болжээ” гэдгийг дурдаад шинэ техник технологи бол бидний боломж гэдгийг хэллээ. Энэ бол Бурханы цаг хугацаа бөгөөд 180 жилийн дараа Түүний энэ цаг хугацаа ирсэн гэдгийг тэмдэглэв. Цэрэнням ах сүмийн гишүүдэд болон оролцогчдод шинэ вэб хуудсаа танилцуулан, хэрхэн ашиглаж, хэрхэн ажиллуулахыг бодитоор үзүүлэн тайлбарлалаа. Бид сүмийн гишүүд болон тэдний найз нөхдийг lds.mn хуудсаар айлчлан, Түүний сайн мэдээнээс суралцахад мөн тэдгээрээс хуваалцахад уриалан дуудаж байна. ■

Бидний “тулгуур чулуу” болох Мормоны Ном унших аян

2013 оны 10 сарын 27-ны өдөр болсон галын дэргэдэх ярилцлага дээр УБ Номлолын ерөнхийлөгч Бэнсон болон сүмийн удирдагчид Монголын цагаан сарын баярын өмнө Мормоны Номыг уншиж дуусгах аян өрнүүлж, онлайнаар унших хуудас болон номын хавчуурга хийж, гишүүдэд түгээсэн билээ. Түүний дагуу гишүүд өөрсдийн итгэлийн тулгуур чулуу болсон судраа амжилттай уншиж дуусгалаа. Үр дүнд нь олон гэр бүл, хувь хүн Бурханы адислалыг хүртэж, олон олон гэрчлэлтэй болсон гэдэгт итгэлтэй байна. Өдөр бүр судруудаас суралцан залбирч, долоо хоног бүр ариун ёслолоосоо хүртэн, эргэн тойрондоо үлгэр жишээ болж, сургаалын дагуу зохистой амьдарснаар бид Түүний өргөмжлөлийг хүртэх болно. Ахан дүүс минь, “амралтын өргөөндөө” хүрэх нарийн бөгөөд шулуун зам дээр маань бат бөгөөд тууштай байлгах төмөр бариул буюу Түүний үгсээс амтархан суралцацгаая! ■

Манай Сүмийн залуус

Сайн мэдээний зарчмын дагуу амьдарч буй хүн байнга зөв шударга, зохистой зүйлсийг эрэлхийлж, өөртөө болоод орчин тойрондоо зөвийг түгээхийг хичээж байдаг. Үүний нэг жишээ бол сүмийн хэсэг залуус санаачлан залуучуудын дунд “MEFY” (Mongolian Especially For Youth) буюу Монголын өсвөр үеийнхэнд зориулсан эерэг нөлөө бүхий дуу, бүжиг, жүжигчилсэн тоглолтыг хамарсан төсөл хэрэгжүүлж, залуусын авьяас билгийг идрүүлэн, хамтдаа зохистой дуу хөгжим сонсож, цагийг зөв зохистой өнгөрөөх үйл ажиллагаануудыг явуулж байна. Тэд анхныхаа дууны клипийг гаргаад байгаа бөгөөд тэдний үйл ажиллагаа болон дуут youtube дээрээс үзэж болно. Та нар youtube.com гэж ороод mefy гэж хайхад л болно. Залуустаа амжилт хүсье. ■



Сүмийн MEFY багийнхан

Ахлагч Нэи ба Систер Нэи




П.Н Шастины нэрэмжит улсын 3-р эмнэлэгт саяхан 25000 ам. долларын үнэ өртөгтэй багцыг Дээрэт Олон Улсын Энэрлийн Байгууллага хандивлалаа.

Хараагүй болохоос хамгаалах, харааг сэргээх нүдний торлог шилэнцрийн мэс засалд эдгээр багц зориулагдсан юм. 2012 онд Мөнхзаяа эмчийг торлог шилэнцэрийн мэс заслын сургалтад Энэтхэг улсад сурахад Дээрэт Олон Улсын Энэрлийн байгууллага хүмүүнлэгийн төслөөр дэмжлэг үзүүлсэн бөгөөд одоо тэрээр улсын 3-р эмнэлгийн Нүдний тасгийн эрхлэгчээр ажиллаж байна. ДООУЭ-ийн байгууллага тус эмнэлэгтэй хамтран харааны бэрхшээлтэй олон хүнд багцуудыг хандивлаж байгаадаа баяртай байна. ■

Ахлагч Нэи 3-р эмнэлгийн эмч нарын хамт

Ерөнхийлөгч Баатарчулуун, Ахлагч Нэи нар ёслолын үеэр



Булган аймаг дахь Ахмадын амралт, сувиллын газарт хандив гардуулах үйл ажиллагаа

ДОУЭ-ийн байгууллага нь 2014 оны гуравдугаар сарын 7 нд Булган аймагт байрлах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сувиллын газарт гал тогооны тоног төхөөрөмж хандивлалаа. Уг сувиллын газарт тэд мэс заслын дараах нөхөн сэргээх эмчилгээ хийлгэж, тав тухтай амрах боломжтой юм.

Тус сувиллын газар олон жил ашигласан гал түддэг зуухаа цахилгаан зуухаар сольж, хоол хийх орчинг сайжруулахад туслах хүсэлтийг бидэнд илгээсэн юм.

Тус сувилалд хандив гардуулан өгөх ёслолд ДОУЭ-ийн байгууллагыг төлөөлөн Сүмийн Үйлчлэлийн төвийн менежер Соёлмаа, Халамжийн Нийгэмлэг ба Үйлчлэлийн төвийн зарим төлөөлөгчид түүнчлэн сувиллын амрагч ахмадууд ба ажилчид оролцлоо.

Цахилгаан зуухтай болсон сувиллынхан амрагчдад түргэн шуурхай, шим тэжээлтэй хоолоор үйлчлэх болсондоо баярлан, ДОУЭ-ийн байгууллагад гүн талархлаа илэрхийллээ. ■



Үйлчлэлийн Төвийн менежер Соёлмаа сувиллынхантай хамт



Булганы ахмадын сувилал дээр

Баянзүрх дүүргийн Хүүхдийн 40-р клиник сувилалд тоног төхөөрөмж гардуулах ёслолын үйл ажиллагаа боллоо.

2014 оны 3-р сарын 6-ны өдөр БЗД-ийн 40-р клиник сувиллын гал тогооны тоног төхөөрөмжийг сайжруулах боломж бидэнд олдсон билээ. Тус сувилал 1962 онд байгуулагдсан бөгөөд хоол тэжээлийн доройтолтой, суурь өвчтэй хүүхдүүдийг сувилан асардаг. Уг цэцэрлэг нь төрийн өмчийн байгууллага юм. Тус клиникт 18 сартайгаас 3 насны ихэнх нь суурь өвчтэй, хоол тэжээлийн доройтолтой хүүхдүүд байдаг. Хоол хүнс, дасгалаар эмчлэх нь тэдний үндсэн эмчилгээ юм. Тэдний гал тогооны тоног төхөөрөмж нь нэлээд хуучирч, олон жил ашиглагдсан бөгөөд зарим нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон байв.

Бидний төслийн хүрээнд стандартын шаардлага хангасан шарах шүүтээ, будаа агшаагч, цахилгаан зуурагч, 2 жижиг дээжийн хөргөгч болон зарим хоолны сав, гал тогооны тавилгыг хандивлалаа.

Энэхүү ёслолын үйл ажиллагаанд БЗД-ийн орлогч дарга Т.Батцогт; Гадаад харилцааны мэргэжилтэн Н.Уянга; Клиник сувилалын дарга О.Туул; Баянзүрх салбарын ерөнхийлөгч Мөнгөнхуяг болон түүний эхнэр; ДОУЭ-ийн

байгууллагын орон нутаг хариуцсан захирал Альвин Нэй болон эхнэр Роксайн Нэй; 18-30 насны залуучуудын зөвлөгч ба залуучуудад зориулсан хавар болох төслийн зохицуулагч Жозеф Линфорд болон түүний эхнэр Лони Линфорд; орчуулагч М.Мөнхцэцэг; хэвлэл мэдээллийнхэн; БЗД-ийн тамгын газрын болон клиникийн ажилчид оролцов. БЗД-ийн орлогч дарга Батцогт, сувилалын дарга Туул болон Нэй ах, эгч хоёр бусад зочид төлөөлөгчдийн хамт тус клиникийн гал тогооны өрөөнд ёслолын туузгыг хайчиллаа.

Клиникийн хамт олон шинэхэн гал тогоотой болсондоо маш их баяртай байсан бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн гайхалтай өргөлд талархаж буйгаа илэрхийллээ. ■

Гайхалтай хандив өргөсөн та нартаа баярлалаа



Шинэхэн 4 ширэмтэй пийшин



Гал тогооны хэрэгслүүд